



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2018 оны 09 сарын 03 өдөр

Дугаар А/517

Булган

Сургалт зохион байгуулах тухай


Монгол Улсын Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 06/06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах болон өрхийн усан хангамж, эрүүл ахуйн талаар иргэдэд мэдлэг олгох сургагч багш бэлтгэх сургалтыг 2018 оны 11 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд зохион байгуулж, хөтөлбөр, төлөвлөгөө гарган ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга /А.Гантөмөр/-д үүрэг болгосугай.
2. Сургалтад шаардагдах зардлыг хавсралтаар баталсугай.
3. Сургалтын үйл ажиллагаанд шаардагдах 8 652 000 /найман сая зургаан зуун тавин хоёр мянга/ төгрөгийг Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /С.Цэдэнлхам/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ



Аймгийн Басаг даргын 2018 оны  
09 дугаар сарын 03-ны өдрийн  
А/517 дугаар захирамжийн хавсралт

Сургалтад шаардагдах зардал

/Төрөг/

№	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн өртөг	Нийт өртөг
1	Томилолт	Хүн/өдөр	27/2	29000	1566000
2	Сургагч багшийн замын зардал	Хүн	2/2	21500	86000
3	Сургагч багшийн зочид буудлын зардал	Хүн/хоног	2/2	60000	240000
4	Сургагч багшийн хөлс	Хүн/өдөр	2/2	150000	600000
5	Өрхийн гарын авлага	Ширхэг	2200	2800	6160000
<b>Дүн</b>					<b>8652000</b>